



МОНГОЛ УЛС  
ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2021 оны 12 сарын 08 өдөр

Дугаар А/МЧ

Мандалговь

Авлигын эсрэг Олон улсын өдрийн  
арга хэмжээнд хөрөнгө гаргах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.1.17, Авлигын эсрэг хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.8, УИХ-ын 2016 оны 51 дүгээр тогтоолоор батлагдсан “Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөр”-ийн 6 дугаар зүйлийн 6.2, Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаалаар батлагдсан “Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам”-ын 2.1.5, Засаг даргын зөвлөлийн хурлын 2021 оны 12 дугаар сарын 08-ны өдрийн 17 дугаар хурлын тэмдэглэлийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Авлигын эсрэг Олон улсын өдрийг тохиолдуулан хүүхэд залуучууд, иргэд, олон нийтэд авлигыг үл тэвчих, шударга ёсны үзлийг төлөвшүүлэх зорилготой зохион байгуулагдсан “Тик ток” уралдааны шагналд 250.000 (Хоёр зуун тавин мянга) төгрөгийг зарцуулсугай.

2. Дээрх арга хэмжээнд шаардагдах 250.000 (Хоёр зуун тавин мянга) төгрөгийг Засаг даргын нөөц хөрөнгөөс зарцуулахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч (Л.Доржбат), нягтлан бодогч (М.Янжиндолгор) нарт зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА



Ц.МӨНХБАТ

Аймгийн Засаг даргын 2021 оны 12 дугаар сарын  
08-ны өдрийн 12 дугаар захирамжийн хавсралт

АВЛИГЫН ЭСРЭГ ОЛОН УЛСЫН ӨДРИЙН "ТИК ТОК"  
УРАЛДААНЫ ДЭД БАЙРНЫ ШАГНАЛ

2021.12.08

№	Багийн нэр	Олгох мөнгөн дүн /мян.төг/
1	Хоёрдугаар байр	250.000
Нийт зардал		250.000

АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН  
ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙН ХЭЛТЭС